

Шимэгчтэх өвчний тархвар зүйн судалгаа хийх төлөвлөгөө, загвар хуудас

Түгээмэл хэрэглэгддэг зарим нэр томъёоны тайлбар

1. Мал эмнэлгийн тархвар зүй. Мал, амьтны өвчний давтамж, эрүүл мэндтэй холбогдон гарах үр дагаврын тархалтыг сүргийн төвшинд эзэн бие, үүсгэгч, хүрээлэн байгаа орчны хүчин зүйлстэй холбож, тэдгээрийн нөлөөг судалдаг шинжлэх ухаан.

2. Тандалт. Өвчнөөс сэргийлэх арга хэмжээг үнэлэх, хэрэгжүүлэх, төлөвлөхөд шаардлагатай мэдээ, мэдээллийг тасралтгүйгээр системтэй цуглуулж дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад үр дүнг ашиглах, түгээх, хэрэглэх үйл ажиллагаа. Тандалтын гол зорилго нь үндэсний мал эмнэлгийн салбар өвчний талаар бүрэн мэдээлэлтэй болж оновчтой зөв шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэхэд оршино.

3. Идэвхтэй тандалт судалгаа нь сүргийн төвшинд хийгдэх ба сорьц цуглуулж шинжлэн, дүн шинжилгээ хийх арга хэмжээ. Судалгаа хийж байгаа аймаг сумын нийт малын 1%-иас багагүй малд түүврийн аргаар хийвэл зохино.

4. Идэвхгүй тандалт. Аман болон шимэгчтэх өвчний тоон мэдээ, мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийх арга.

5. Өвчний голомт. Өвчин гарсан эрчимжсэн аж ахуй, хот айлтай бэлчээр, ус давхцан нутаглаж байгаа хот айл, эрчимжсэн аж ахуйн бэлчээр, нутгийг хамруулан халдварын голомтын бүс гэнэ.

6. Өвчний тохиолдол, тохиолдлын тодорхойлолт. Тухайн өвчний эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн малыг толгой бүрээр нэг тохиолдол гэж үзэн мэдээллийг цуглуулах ба тархвар зүйн нэгжийн хувьд өрх буюу аж ахуйг нэг тохиолдол гэж үзнэ. Тохиолдол гэдэгт тухайн өвчний батлагдсан болон сэжигтэй тохиолдлын тодорхойлолтыг ашиглана. Өвчний тодорхойлолт өвчин тус бүрт өөр өөр байна

7. Дэгдэлт судалгаа. Өмнө нь тодорхой цаг хугацаанд гарч байсан тухайн өвчний тохиолдлын тоо огцом нэмэгдэх болон гарч байгаагүй өвчний тохиолдол тухайн бүс нутагт шинээр бүртгэгдэхийг дэгдэлт гэнэ. Дэгдэлтийн үед мэргэшсэн эпидемиологичдын багийг малын ерөнхий эмчийн шийдвэрээр томилж, тухайн халдварын гарал, үүсэл, шалтгаан нөхцөл, халдварын цар хүрээг судалж, зөвлөмж боловсруулан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ.

8. Эрсдэлийн үнэлгээ. Шимэгчтэх өвчний эрсдэлийн ерөнхий ба тусгай үнэлгээ хийнэ. Шимэгчтэх өвчин бүртгэгдсэн аймаг, сумтай хил залгаа аймаг, сумдад тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлт хүчин зүйлсийг үнэлэх арга хэмжээг ойлгоно.

9. Тэмцэх арга хэмжээний хэрэгжилт. Тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлсэн хүмүүсээс асуулга авах, шаардлагатай тохиолдолд тухайн өрх, аж ахуйн мал, амьтнаас сорьц цуглуулж шинжлэх замаар дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн бодлогын баримт бичигт шаардлагатай өөрчлөлт оруулах, дэглэм хэрэгжүүлэхэд оролцсон байгууллага, иргэдэд энэ тухай эргэн мэдээлэх цогц үйл ажиллагаа.

10. Өвчнийг эрт илрүүлэх. Тухайн өвчний шинж тэмдэг илэрсэн дарууд мэргэжлийн байгууллагад мэдээлэх, мэргэжлийн байгууллага нь өвчнийг эрт үед нь үнэн зөв, шуурхай оношлох арга хэмжээ болно. Өвчнийг эрт илрүүлэх чадавхийг

бүрдүүлэхийн тулд тухайн өвчин эмгэг болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар малын эмч нарт сургалт, сурталчилгаа зохион байгуулах, малчид, ард иргэдэд тайлбарлан таниулах арга хэмжээ нь чухал ач холбогдолтой.

ТАРХВАР ЗҮЙН СУДАЛГАА ХИЙХ ЕРӨНХИЙ ЗААВАР

1. Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Энэхүү заавар нь "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 8-р зүйл, 21-р зүйлийн 21.4 дэх хэсэгт заасан тархвар зүйн судалгаатай холбогдох бусад харилцааг зохицуулна.

1.2. Тархвар зүйн судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй, оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг цаашдын бодлого шийдвэр гаргахад ашиглана.

1.3. Шимэгчтэх өвчний чиглэлээр хийгдэж байсан тархвар зүйн судалгааны үр дүнг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дараа жилийн тархвар зүйн судалгааг төлөвлөн хэрэгжүүлнэ.

1.4. Тархвар зүйн судалгаанд шаардагдах статистикийн мэдээллийг мал эмнэлгийн тасгаас гаргуулан дээд шатны байгууллагад хүргүүлэх, орон нутгийн төвшинд статистик мэдээллийг ашиглан тархвар зүйн холбогдох судалгааг төлөвлөн хэрэгжүүлнэ.

1.5. Шимэгчтэх өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн жил бүрийн шимэгчтэх өвчний тархвар зүйн судалгааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дараа жилийн төсөв, төлөвлөгөөнд арга хэмжээг тусгаж хэрэгжүүлнэ.

2. Хоёр. Тархвар зүйн судалгаа хийх, зураглал үйлдэх.

2.1. Тархвар зүйн судалгааны төрөл бүрийн аргаас сонгон, хавсралтаар баталсан судалгааны хуудасны загварыг өвчний онцлогт тохируулан өөрчилж ашиглана.

2.2. Мал, амьтны шимэгчтэх өвчний онош тодорхойгүй дэгдэлтийн үед тархвар зүйн судалгаа гүйцэтгэнэ.

2.3. Тархвар зүйн төлөвлөгөөний дагуу улсын хэмжээнд хэрэгжүүлэх тархвар зүйн судалгааны удирдамжийг шимэгчтэх өвчин хариуцсан мэргэжилтэн Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, малын ерөнхий эмч баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.

2.4. Аймгийн хэмжээнд зохион байгуулах тархвар зүйн судалгааны удирдамжийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын дарга баталж, аймгийн мал эмнэлгийн газрын шимэгчтэх өвчин харуцсан мэргэжилтэн хэрэгжилтийг зохион байгуулна.

2.5. Мал эмнэлгийн тасаг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 8.1-д заасан тархвар зүйн судалгаа хийж, мал, амьтны шимэгчтэх өвчнийг тандах үйл ажиллагааг 4-р сараас эхлэн 10-р сарын 15-г хүртэл хийж, үр дүнг дээд шатны байгууллагад 11 сарын 01-ний дотор хүргүүлнэ.

3. Гурав. Үр дүнг тайлагнах, нийтэд мэдээлэх

3.1. Тархвар зүйн судалгааны үр дүнг үндэслэн шимэгчтэх өвчний тархвар зүйн зураглалыг сум, аймгийн төвшинд болон улсын хэмжээнд нэгтгэн 12-р сарын 15-ны дотор Мал ерөнхий газар үйлдэнэ.

3.2. "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 8-р зүйлийн 8.6 дахь хэсэгт заасан албан тушаалтан тархвар зүйн судалгааны үр дүнг холбогдох хуульд заасан хугацаанд нь дээд шатны байгууллагад хүргүүлэх ба үр дүнг үндэслэн олон нийтэд мэдээлнэ.

4. Гурав. Үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг

4.1. Мал эмнэлгийн салбарын байгууллага

4.1.1. Судалгааны хуудсыг өвчин бүрийн онцлогт тохируулан тархвар зүйчийн боловсруулснаар мэдээлэл цуглуулна.

4.1.2. Тархвар зүйн судалгааны үр дүнг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.

4.1.3. Улсын хэмжээнд тархвар зүйн судалгааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу жил бүрийн тархвар зүйн судалгааг Мал эмнэлгийн тасаг зохион байгуулна.

4.1.4. Аймаг, сумын төвшинд зохион байгуулах тархвар зүйн судалгааг тухайн шатны мал эмнэлгийн байгууллага төлөвлөж хэрэгжилтийг зохион байгуулна.

4.1.5. Улс болон аймгаас зохион байгуулах тандалтын арга хэмжээнд сүлжээ лаборатори, аймаг, сумын мал эмнэлгийн байгууллагууд удирдамжийн дагуу оролцож, холбогдох ажлуудыг гүйцэтгэнэ.

4.1.6. Шимэгчтэх өвчний эрсдэлийн ерөнхий үнэлгээг малын ерөнхий эмчийн шийдвэрээр гүйцэтгэх ба үнэлгээний олон улсын нийтлэг аргачлал, арга зүйн дагуу тухайн баг боловсруулна.

4.1.7. Шимэгчтэх өвчний халдварын эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн тухайн шатны Засаг дарга, төр захиргааны холбогдох байгууллагуудтай хамтран урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

4.1.8. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгдийн Хурал, Засаг дарга

4.1.9. Мал эмнэлгийн тасгаас боловсруулсан орон нутагт хэрэгжүүлэх тархвар зүйн судалгааны жилийн төлөвлөгөөг баталж, зардлыг шийдвэрлэж, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

4.1.10. Засаг дарга нь тархвар зүйн судалгааг орон нутгийн төвшинд гүйцэтгэх боломжоор хангаж баг, хорооны Засаг дарга нар нь сонгогдсон өрхүүдэд товыг мэдээлж, бэлэн байдлыг хангуулна.

4.1.11. Орон нутгийн мал, амьтны өвчний тархвар зүйн мэдээллээр малчид, ард иргэдийг хангаж, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мал эмнэлгийн тасаг болон аймгийн мал эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллана.

4.1.12. Орон нутгаас отор нүүдэл болон шилжилт хөдөлгөөн хийх талаарх шийдвэр гаргахдаа мал, амьтны өвчний тархвар зүйн судалгааны дүн мэдээг үндэслэн бусад орон нутагтай хэлэлцээр хийж шийдвэрлэнэ.

Тархвар зүйн судалгаа хийх төлөвлөгөө

Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх угаалга, туулга, боловсруулалтын дараах тандалт	Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх угаалга, туулга, боловсруулалтад хамрагдсанаас хойш 14-28 хоногийн дараа зохион байгуулна.
Тэмцэх арга хэмжээний хэрэгжилт	Өвчний шинж тэмдэг илэрч эмчилгээ хийснээс хойш 14 хоногийн дараа давтан асуумж, судалгаа, лабораторын шинжилгээг гүйцэтгэх ба аймаг орон нутгийн мал эмнэлгийн газар зохион байгуулна.
Шимэгчтэх өвчний халдварын эрсдэлийн үнэлгээ	Шимэгчтэх өвчний эрсдэлийн загварыг ашиглан үнэлж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ. Шимэгчтэх өвчин гарсан үед орон нутагт эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
Тандалт	Идэвхтэй болон идэвхгүй тандалтын хэлбэрээр тархвар зүйн мэдээлэл цуглуулах.

Шимэгчтэх өвчний тархвар зүйн судалгаа хийх дараалал

1. Анхан шатны мэдээлэл цуглуулах:
 - 1.1. Аймаг, сум, багийн нэр;
 - 1.2. Судалгаа хийх малчин, аж ахуй нэгжийн нэр, утасны дугаар;
 - 1.3. Аж ахуй эрхлэх хэлбэр, мал, амьтны төрөл, тоо;
 - 1.4. Тухайн орон нутгийн малын эмчийн нэр, утасны дугаар;
2. Тархалтын судалгаанд бэлтгэх:
 - 2.1. Багийн гишүүдийг бүрдүүлэх, удирдамж батлуулах;
 - 2.2. Багийн гишүүн тус бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох;
 - 2.3. Шаардлагатай материал тоног төхөөрөмж;
 - 2.4. Судалгаанд шаардагдах зүйлс;
 - 2.5. Сорьцын хэрэгсэл (Зүү, скальпел, петрийн аяга, сорьц авах сав, бодисын шил, формалины 10% уусмал) ;
 - 2.6. Хэвлэсэн САЗ бусад холбогдох журмууд;
 - 2.7. Тээврийн хэрэгсэл;
3. Тархалтын судалгаа хийх:
 - 3.1. Шимэгчтэх өвчний халдварлалтын идэвхижил өндөртэй бүс нутагт судалгаа хийх;
 - 3.2. Асуумжийн дагуу аж ахуйн нэгж, малчин, мал бүхий иргэдээс мэдээлэл цуглуулах;
 - 3.3. Сорьц авч лабораторид илгээнэ. (Сорьцын тоо тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаална;
4. Тайлагнах: Судалгаа эхлэхээс өмнө цуглуулсан мэдээлэл (Сорьц авсан лабораторийн шинжилгээний хариу гэх мэт) болон газар дээрээс цуглуулсан мэдээлэлд үндэслэж тайлан бичиж судалгаа хийснээс хойш 14 хоногийн дотор эцсийн тайланг хүлээлгэн өгнө. Тайлан нь үндсэн мэдээллээс гадна доорх мэдээллийг заавал агуулна.
 - 4.1. Цаг хугацааны хувьд (тархвар зүйн муруй зурах замаар таамаглал дэвшүүлэх)
 - Эхний тохиолдол хэзээ илэрсэн бэ?
 - Халдварлалт ямар хугацаанд үргэлжилсэн бэ?
 - Өвчний шинж тэмдэг илэрсэн үед ямар шинжилгээ хийсэн бэ?
 - Сүргийн хооронд өвчлөлийн төвшингийн ялгаа байгаа эсэх?
 - Халдварлалтын түвшин өндөр байгаа эсэх?
 - Халдварлалтын түвшин мал, амьтны наснаас шалтгаалж байгаа эсэх?
 - 4.2. Газар нутгийн хувьд (Газрын зураг дээр дэгдэлтийн байршлыг оруулах, усны эх үүсвэр, уул нуруу гэх мэт)
 - Газар зүйн хувьд ямар нэг сэжиг илэрсэн үү?
 - Мал аж ахуйн хэлбэрээс шалтгаалж төрөл, зүйлийн хооронд ялгаа байгаа эсэх?
 - Газар зүйн хувьд ямар ямар эрсдэл байж болох вэ?
 - 4.3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хувьд
 - Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан талаарх бүртгэл;
 - Урьдчилан сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтад төвлөсөн хугацаанд мал, амьтныг бүрэн хамруулсан эсэх;
 - 4.4. Таамаглал дэвшүүлэх

- Халдварын эх үүсвэр
- Халдвар тархах хэлбэр
- Халдвар гарахад нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлс

4.5. Зөвлөмж өгөх

- Халдварлалтын төвшинг тогтоох судалгааны баг нь оролцогч талууд болох малчид, аж ахуйн нэгж, мал бүхий иргэд болон холбогдох мэргэжлийн байгууллагуудад зориулсан зөвлөмж боловсруулж хүргүүлнэ.

ТАНДАЛТЫН СУДАЛГААНЫ ЗАГВАР / МАЛЫН ЭМЧЭЭС АВАХ /

Асуумж дугаар : |_|_|_|_|

Аймаг _____ Сум _____ Баг _____

1. Асуумж авсан огноо: |_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|

2. Байршил: Хот айл дахь өрхийн тоо уртраг(N) |_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|, өргөрөг (E) |_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|

3. Малчны овог: нэр:, Утасны дугаар:

4. Малчны хотонд байгаа мал, амьтны тоо төрөл бүрээр?

	Нийт мал тоо	Адуу	Үхэр	Тэмээ	Ямаа	Хонь	Нохой	Гахай

5. Тухайн өрхийн малд дараах шинж тэмдэг илэрсэн үү? Илэрсэн шинж тэмдгийг дугуйлна уу !

- a) Халуурах
- b) Номойрох
- c) Тэжээлийн дуршилгүй болох
- d) Хашаа хороо шөргөөх
- e) Турж, эцэх
- f) Үс, ноос нь халцарч унах
- g) Арьсан дээр жижиг зангилаанцар үүсэх
- h) Ярших
- i) Салст бүрхүүл нь цайх
- j) Ханиалгах
- k) Цустай чацга алдах

Өөр онцгой шинж тэмдэг ажиглагдсан уу? Ажиглагдсан бол шинж тэмдгийг бичнэ ҮҮ.

.....

6. Өвчний явц ямархуу байсан бэ? Доогуур нь зурах

Хэт цочмог /1-3 хоног/, Цочмог /3-10 хоног/, Цочмогдуу /6-10 хоног/, Ужиг /10-аас дээш хоног/

7. Хэзээнээс эхэлж дээрх шинж тэмдэг мал, амьтанд илэрсэн бэ? Шинж тэмдэг илэрсэн хугацааг бичнэ. |__|__|__| |__|__| |__|__|
8. Ямар малд шинж тэмдэг анх илэрсэн бэ? Шинж тэмдэг илэрсэн малын төрлийг сонгон тэмдэглэх. Тэмээ |__|, Адуу |__|, Үхэр |__|, Хонь |__|, Ямаа |__|
9. Тухайн шинж тэмдэг нэг зэрэг олон малд илэрсэн үү? Тийм |__|, Үгүй |__|, Тийм бол хэдэн малд илэрснийг бичих |__|__|__|
10. Одоогийн байдлаар өвчилсөн малын тоо? Өвчилсөн малын тоог бичих. Тэмээ |__|__|, Адуу |__|__|, Үхэр |__|__|, Хонь |__|__|, Ямаа |__|__|
11. Одоогийн байдлаар үхсэн малын тоо хэд вэ? Үхсэн малын тоог бичнэ үү. Тэмээ |__|__|, Адуу |__|__|, Үхэр |__|__|, Хонь |__|__|, Ямаа |__|__|
12. Өвчилснөөс хойш мал, амьтны үхсэн хугацааг дунджаар хэлнэ үү? Хугацааны урд тэмдэглэх. |__| 4-7 хоног, |__| 8-10 хоног, |__| 14-өөс дээш хоног
13. Өвчилсөн мал ойролцоогоор хэд хоногийн дараа эдгэрч байна вэ? Эдгэрч байгаа хоногийн тоог бичих. Тэмээ |__|__|, Адуу |__|__|, Үхэр |__|__|, Хонь |__|__|, Ямаа |__|__|
14. Дээрх шинж тэмдэгтэйгээр өвчилсөн малд ямар эмчилгээ хийсэн бэ? Хийсэн эмчилгээг бичих.

15. Хэдэн мал эмчилсэн бэ? |__|__|__|
16. Эмчилгээний үргэлжилсэн хугацаа? |__|__|__|
17. Өвчилсөн мал, амьтныг тусгаарласан уу?
 Тийм |__|, Үгүй |__|, Тийм бол хэдэн хоног тусгаарласныг бичих |__|__|__|
18. Өвчин гарснаас хойш халдваргүйжүүлэлт хийсэн үү?
 Тийм |__|, Үгүй |__|, Тийм бол ямар бэлдмэлээр
- Хэдэн удаагийн давтамжтай халдваргүйжүүлэлт хийсэн бэ? Халдваргүйжүүлэлт хийсэн тоог бичнэ үү. |__|__|__|

Судлаачийн нэр:

Утасны дугаар:

И-мэйл хаяг:

Судалгаанд идэвхтэй оролцсон танд баярлалаа !

**ШИМЭГЧТЭХ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨТ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ДАРААХ ТАНДАЛТЫН ХУУДАС /МАЛЫН ЭЗНЭЭС АВАХ АСУУМЖ/**

Асуумж дугаар : |_|_|_|

Аймаг _____ Сум _____ Баг _____

1. Асуумж авсан огноо: |_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|
2. Байршил: Хот айл дахь өрхийн тоо уртраг(N)
|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|, өргөрөг (E) |_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|
3. Малчны овог нэр.....
4. Утасны дугаар |_|_|_|_|_|_|_|_|_|_|_|_|
5. Танай мал шимэгчтэх өвчнөөс сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээнд хамрагдсан уу? Хамрагдсан бол хамрагдсан төлөвлөгөөт арга хэмжээг тэмдэглэнэ үү.
Угаалга |_|_|, Туулгалт |_|_|, Боловсруулалт |_|_|, Үхрийн арьсны гуурын боловсруулалт |_|_|
6. Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээнд /угаалга, туулга, боловсруулалт/ хамрагдахаас өмнө танай малд өвчний шинж тэмдэг илэрсэн үү?
Тийм |_|_|, Үгүй |_|_|
7. Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээнд /угаалга, туулга, боловсруулалт/ хамрагдсанаас хойш танай малд өвчний шинж тэмдэг илэрсэн үү ?
Тийм |_|_|, Үгүй |_|_|
8. Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээнд хамрагдаагүй бол шалтгаан
a. Угаалга, туулга, боловсруулалт хийгдсэн талаар мэдээгүй |_|_|
b. Хамрагдах хүсэлтэй ч малын эмч ирээгүй |_|_|
c. Манай хот айл хүн хүч муутай байсан учраас хамрагдаагүй |_|_|
d. Малчин өөрөө малдаа угаалга, туулга, боловсруулалт хийсэн |_|_|
e. Бусад шалтгааныг бичих |_|_|
.....
.....
9. Танай мал сүрэгт сүүлийн 6 сард дараах шинж тэмдэг илэрсэн үү ? Хариултыг дугуйлна (өвчний онцлогт тохируулан хариулт бэлтгэж хамгийн ихдээ 3-ыг сонгоно)
a. Номойрох
b. Хашаа хороо шөргөөх
c. Турж, эцэх
d. Үс, ноос нь халцарч унах
e. Арьсан дээр жижиг зангилаанцар үүсэх
f. Арьсны уян хатан чанар алдагдаж ярших
g. Халуурах
h. Цустай чацга алдах
i. Салст бүрхүүл нь цайх
j. Ханиалгах

10. Сүүлийн 6 сарын хугацаанд гаднаас мал авсан уу ?

Тийм |__|, Үгүй |__|

11. Хэрэв гаднаас мал, амьтан худалдаж авсан бол хэзээ?

|__|_|__|_|__|_|__|_|__|

12. Худалдаж авсан мал, амьтны төрөл ?

Тэмээ |__|_|__, Адуу |__|_|__, Үхэр |__|_|__, Хонь |__|_|__, Ямаа |__|_|__|

13. Айлын малтай малаа нийлүүлсэн үү?

Тийм |__|, Үгүй |__|

14. Нийлүүлсэн бол хэдэн удаа? |__|_|__|

ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮНЭЛЭХ ЗАГВАР /МАЛЫН ЭЗНЭЭС АВАХ АСУУМЖ/

Асуумж дугаар : |__|_|__|_|__|

Аймаг _____ Сум _____ Баг _____

1. Асуумж авсан огноо : |__|_|__|_|__|_|__|_|__|

2. Байршил: Хот айл дахь өрхийн тоо уртраг(N)

|__|_|__||__|_|__||__|_|__|, өргөрөг (E) |__|_|__||__|_|__||__|_|__|

3. Малчны овог нэр.....

4. Утасны дугаар |__|_|__|_|__|_|__|_|__|_|__|

5. Сүүлийн 6 сарын хугацаанд гаднаас мал авсан уу ?

Тийм |__|, Үгүй |__|

6. Хэрэв тийм бол

• Хэзээ: сар |__|_|__| өдөр |__|_|__|

• Малын төрөл: үхэр |__|, хонь |__|, ямаа |__|, адуу |__|, тэмээ |__|, нохой

• Малын тоо: үхэр |__|, хонь |__|, ямаа |__|, адуу |__|, тэмээ |__|, нохой

7. Энэ онысарын.....-нээссарын.....-ны хооронд гэрээт мал эмнэлгийн нэгжийн малын эмч үйлчилгээ үзүүлсэн үү ?

|__| Тийм, |__| Үгүй, |__| Мэдэхгүй

8. Гэрээт мал эмнэлгийн нэгжийн эмч мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлсэн бол хэдэн удаа үйлчилгээ үзүүлсэн бэ?

1 |__| , 2 |__|, 3 -с дээш |__|

9. Ямар үйлчилгээ үзүүлсэн бэ?

Үзлэг |__|, Тарилга |__|, Туулгалт |__|, Шинжилгээ |__|, Угаалга |__|, Боловсруулалт |__|

10. Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх төлөвлөгөөт ажлын дараах тандалтын шинжилгээнд танай малыг хамруулсан уу?

|__| Тийм, |__| Үгүй, |__| Мэдэхгүй

Тийм бол Огноо |__| |__| |__| |__| |__| |__| |__| |__|

11. Танай хотонд байгаа мэдрэмтгий малын тоо толгой /малын төрөл, нас/

Насны бүлэг	Тоо толгой				
	Үхэр	Хонь	Ямаа	Адуу	Тэмээ
12 сараас доош (төл)					
12 сараас дээш					
Хээлтүүлэгч					

12. Мэдрэмтгий мал сүргийн тоо, малын төрөл? /Өвчин гарах үеийн/

Насны бүлэг	Тоо толгой					
	Үхэр	Хонь	Ямаа	Адуу	Тэмээ	Нохой
12 сараас доош (төл)						
12 сараас дээш						
Хээлтүүлэгч						

**ШИМЭГЧТЭХ ӨВЧНИЙ ХАЛДВАРЛАЛТЫН ҮЕД ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ ЗАГВАР
/МАЛЫН ЭМЧЭЭС АВАХ АСУУМЖ/**

Үнэлгээ	Асуулт	Тэмдэглэл	Үнэлгээ	
			Тийм	Үгүй
Үйл явдлын ерөнхий шинж чанар	Шимэгчтэх өвчин үү?			
	Халдвар дамжих олон зам бий юу?			
	Халдварын голомтыг хяналтад авах чадвар бий юу?			

	Халдварын цар хүрээ хурдан тэлж байна уу?				
	Шуурхай хариу арга хэмжээг авч эхэлсэн үү?				
1. Аюулын үнэлгээ					
Биологийн хүчин зүйл	Боловсруулалтад хэрэглэсэн эмийн бэлдмэл таарч байгаа эсэх?				
	Ямар мал, амьтан өвчилж байгаа вэ?				
	Олон мал, амьтан өвчилсөн үү?				
Эмнэлзүйн хүчин зүйл	Эмнэлзүйн шинж тэмдэг тодорхой юу?				
	Эмнэлзүйн явц хүндрэлийн зэрэг өндөр үү?				
	Үхэл хорогдол ихтэй юу?				
	Өвчний нууц үе урт уу?				
	Малын нас хүйсийн ялгаа байна уу?				
2. Өртөх эрсдэлт хүчин зүйлийн үнэлгээ					
Эрсдэлт хүчин зүйлийн үнэлгээ	Халдвар тархаах эрсдэлт хүчин зүйл юу вэ?				
	Улирлын нөлөө бий юу?				
	Эрсдэлт хүчин зүйлст чиглэсэн өвөрмөц арга хэмжээ бий юу? (Шимэгчтэх өвчин бүртгэгдсэн болон сэжигтэй бүсэд хамаарах орон нутгаас халдвар дамжиж болох эрсдэлт хүчин зүйлсийг үнэлнэ)	Отор нүүдэл			
		Алдуул мал			
		Зэрлэг амьтан			
		Уралдаан наадам			
		Хүн, малын хөдөлгөөн			
		Байгалийн эрсдэлд өртөх эрсдэл			

		Малын худалдаа байнга хийгддэг үү?		
		Малчид тухайн өвчний талаар хэр мэдэх вэ?		
		Малын эмч нар тухайн өвчний талаар хэр зэрэг мэддэг вэ?		
Эзэн биеийн хүчин зүйл	Мэдрэмтгий мал, амьтны тоо толгой тодорхой юу?			
	Эмнэл зүйн шинж тэмдэг тодорхой илэрдэг амьтан юу вэ?			
	Мэдрэмтгий мал, амьтан тухайн өвчнөөс сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээнд хамрагдсан уу?			
3. Нөхцөл байдлын үнэлгээ				
Нийгэм эдийн засгийн хүчин зүйл	Халдвар нь одоогийн гарсан орон нутгийн хил хязгаараас давах боломжтой юу?			
	Урьд нь тухайн орон нутагт бүртгэгдэж байсан уу?			
	Мал нь өвчилсөн өрхүүд бүгд мал эмнэлэгт мэдээлж амжсан уу?			